

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 7 сарын 29-ний өдөр

№ 20/26

Улаанбаатар хот

2020 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

Ц.ОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 7 сарын 29-ний өдөр

№ 20/27

Улаанбаатар хот

“Лэнд Хэтэвч” цахим төлбөр тооцооны үйлчилгээг “Супер Ап Хэтэвч” ХХК-д шилжүүлэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.10 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 5 сарын 20-ны өдрийн А-174 тоот тушаал, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 19/61 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК нь Монголбанкнаас цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсантай холбогдуулан Компанийн эрхэлж буй “Лэнд Хэтэвч” цахим төлбөр тооцооны үйлчилгээг 2020 оны 7 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон зогсоож, 2020 оны 8 сарын 01-ний өдрөөс “Супер Ап Хэтэвч” ХХК-д шилжүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх заалттай холбогдуулан “Лэнд Хэтэвч” үйлчилгээнд бүртгэлтэй хэрэглэгч, бусад оролцогчдын бүртгэл, цахим хэтэвчийн данс, цахим мөнгөний үлдэгдлийг заасан хугацаагаар тасалбар болгон “ЛэндМН ББСБ” ХК-иас “Супер Ап Хэтэвч” ХХК-д шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
3. “Лэнд Хэтэвч” үйлчилгээг “Супер Ап Хэтэвч” ХХК-д шилжүүлэхтэй холбоотой ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулах, Компанийн цахим төлбөр тооцооны үйлчилгээг охин компанид шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-т даалгасугай.



ТХЗ-ИЙН ДАРГА:

Ц.ОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 7 сарын 29-ний өдөр

№ 20/28

Улаанбаатар хот

2020 оны төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. COVID-19 вирусын цар тахлаас үүдэн эдийн засагт үүссэн нөхцөл байдалтай уялдуулан Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/03 тоот тогтоолоор баталсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төсөвт, нэмэлт, өөрчлөлт оруулж, энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2020 оны төсөвт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг компанийн үйл ажиллагаанд мөрдөж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

/Ц.ОДМАА/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 7 сарын 29-ний өдөр

№ 20/29


Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 болон 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.12 дэх хэсэг, ТУЗ-ийн 2020 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Дижитал Молл” ХХК-тай дараа төлбөрт худалдан авалтын санхүүжилтын “SUP Ray” үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. “Дижитал Молл” ХХК-тай байгуулах Хамтран ажиллах гэрээний нөхцөлийг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд “Дижитал Молл” ХХК-тай Хамтран ажиллах гэрээний нөхцөлийг харилцан тохирч байгуулах, гэрээний хэрэгжилтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



/С.БОРГИЛ/



/Ж.ЖАРГАЛСҮРЭН/



/Ч.НОМИН/



/С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 7 сарын 29-ний өдөр

№ 20/30

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 болон 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.12 дэх хэсэг, ТУЗ-ийн 2020 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “SuperUp” хэтэвчээр дамжуулан “ЛэндМН ББСБ” ХК-ийн үйлчилгээг хэрэглэж буй хэрэглэгчийн төлбөр тооцоог гүйцэтгэх, түүнтэй холбогдуулан “Супер Ап Хэтэвч” ХХК-тай төлбөр тооцооны үйлчилгээний гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. “Супер Ап Хэтэвч” ХХК-тай байгуулах Төлбөр тооцооны үйлчилгээний гэрээний нөхцөлийг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд “Супер Ап Хэтэвч” ХХК-тай гэрээний нөхцөлийг харилцан тохирч байгуулах, гэрээний хэрэгжилтийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.

ТУЗ-ийн гишүүд:



/С.БОРГИЛ/



/Ж.ЖАРГАЛСҮРЭН/



/Н.ЦЭВЭГМИД/



/Ч.НОМИН/



/С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 7 сарын 29-ний өдөр

№ 20/31

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 болон 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.12 дэх хэсэг, ТУЗ-ийн 2020 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/04 тоот тогтоолоор эрх олгосныг үндэслэн Компанийн Эх үүсвэрийн 2020 оны төлөвлөгөөний дагуу Итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө татан төвлөрүүлэх зорилгоор “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-тай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээнд заасан нөхцөлийн дагуу холбогдох хөлс төлөхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-тай байгуулах Зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

	/Ц.ОДМАА/		/В.БАЯРСАЙХАН/
	/О.БОЛДБААТАР/		/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
	/Ч.НОМИН/		/С.ЭНХ-АМГАЛАН/
	/С.БОРГИЛ/		/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ᠮ.1118207200
lendmn